

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 53 (2317)

1974 оны 7 дугаар сарын 15

ДАВАА

БҮХ НИЙТЭЭРЭЭ ХАДЛАНД ГАРЦАГААЙ

Манай аймаг 79,4 мянган га хадлангийн талбайтай бөгөөд өвөл, хаврын улиралд шаардагдах бүх тэжээлийн 50 орчим хувийг бэлтгэдэг юм.

Энэ онд аймгийн хэмжээгээр 95,7 мянган тонн өвс бэлтгэнэ. Хадлангийн ажилд бүрэн механикжсан бригад, салаа 32, морин халуурын 87, гар халуурын 30 бригадад трактор 400 гаруй, трактор ба морин халуур 472, тармуур 261, морь 2,0 мянга орчим, 2,7 мянган хүн ажиллахаар бэлтгээд байна.

Мөн 15,0 мянга гаруй хүнд хадлангийн даалгаврын хуудас гардуулан тэд витаминт тэжээл, өвсөн дарш, өвсний мушгиа бэлтгэхээр зохион байгуулагджээ. Одоогийн байдлаар Мөнгөнморьт сум бэлтгэлээ эртээс базааж хадландаа жигдрэн ороод байна.

Гэвч олонхи сум өвс ургамал тагчир гэсэн шалтгаан тооцож, хадланд шуурхай гарахгүй удааширсаар байна.

Баян, Эрдэнэсант, Бүрэн, Баянжаргалан сумд саяхан болтол хадах газраа сонгон олж, зохих зохион байгуулалт хийгээгүй байлаа. Энэ нь өвс хадланг богино хугацаанд шим тэжээлтэй үед нь бэлтгэхэд ихээхэн саад учруулж болзошгүй байна. 1973 оны 9 дүгээр сарын 15 гэхэд Баянжаргалан, Баян сумд бэлтгэх өвснийхөө 52,6—57,5 хувь, Баянцагаан, Заамар, Дэлгэрхаан сумд 86,2—91,2 хувийг бэлтгэж байсан дутагдлыг давтаж болохгүй.

Иймд хадлан тэжээл бэлтгэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгон явуулж өндөр настан, гэрийн ажилтай хүмүүс сургуулийн сурагчид амарч байгаа оюутнууд, ажилчин, албан хаагч, нормын ажилчдын насны байдал, ажлын онцлогийг харгалзан бэлтгэх өвсний норм, биелүүлэх хугацааг заасан даалгаврын хуудас гардуулан өгч, түүний биелэлтийг хүн нэг бүртэй нарийн тооцож гүйцэтгүүлэх хэрэгтэй.

Хадлангийн талбайн ургацыг дахин тогтоосны үндсэн дээр хадлан бэлтгэх төлөвлөгөөг биелүүлэхэд шаардагдах техник, хүн хүчний тооцоог нарийвчлан хийж, холбогдох арга хэмжээг яаралтай авбал зохино. Юуны урьд хадлан өвсний богино хугацаанд арвин их бэлтгэхийн ач холбогдол, энэ талаар нам, засгаас тавьж байгаа зорилтыг нийт хөдөлмөрчдөд ухуулсны төрөл бүрийн аргаар гүнзгий тайлбарлан ойлгуулж нийтийн хүчийг энэ чухал компанид ажилд чиглүүлэх арга хэмжээ авахад орон нутгийн нам, улс, МҮЭ, ХЗЭ-ийн болон эмэгтэйчүүдийн байгууллагууд нэгдсэн төлөвлөгөө чиглэлтэй шуурхай арга хэмжээ авах нь одоогийн чухал зорилт болж байна.

Хадланг чанар сайтай бэлтгэхэд хадланчид бүр анхаарах ёстой. Үүний тулд ЗХУ ба бусад социалист орнуудын туршлагаар бороотой үед бэлтгэсэн өвснийг молоор хөндийж шовгор ба бөмбөгөр хэлбэртэй нуруулах, өвөлжөө, хаваржаа бүрт гар дарсны нүх бэлтгэн бууц зам, гуу жалганы хиаг, аги, шарилж бусад өвсийг түүж хэрчиг жижиглэн даршлах нь зүйтэй. Баянцогт, Заамар сумдад өвсөөр санаж мушгиа хийдэг туршлагыг нийт САА, ТАА болон ойт хээрийн бүсийн нэгдлүүд нэвтрүүлэх шаардлагатай юм. Угтаалын САА-н туршлагаар хадлангийн талбайд загон татаж хадах талбайн сэлгээ тогтоон нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх, улс, аймгийн аварга хадланч, Өндөрширээт сумын тракторчин Н. Болдын өдөрт хадах талбайг хэмжин загон татаж гуу жалга бартаатай хэсгийг өдөрт, тэгш талбайг шөнө, бороо чийгтэй үед өвс нь хялбархан хатадаг энгэр налуу өндөр газрын өвсийг эхлэн хаддаг туршлагыг бүх хадланчдад эзэмшүүлэх зохино.

Хадлангийн төлөвлөгөөг хугацаанд нь чанартай биелүүлсэн хадланчдын ар гэрийн хүмүүст баяр хүргэх, мөн хадлангийн хугацаанд олон удаа уралдаанд шалгарч сайшаагдсан хадланчдыг ажлын эцэст шалгаруулан байр эзлүүлж материаллаг зүйлээр шагнах зэрэг социалист уралдаан урамшил шагналын олон талт хэлбэрийг өргөн ашиглаж хадланчдын хөдөлмөрийн идэвхийг аль болохоор өрнүүлэх хэрэгтэй.



Баянцагаан сум—нэгдлийн саальчин Д. Лхамсүрэн сүүлийн 3 жил дараалан сүүний төлөвлөгөөг давуулж, энэ оны бодын хөөвөр бэлтгэх даалгаврыг биелүүлж хариуцсан үнээ бүрээс 500 литр сүү сааж, төлийг МАХН-ын Төв Хорооны 1971 оны IX бүгд хурлын заалтын хэмжээнд хүргэн бойжуулав.

Т. ГАВАА

ТӨЛӨВЛӨГӨӨТ ТАВАН ЖИЛИЙН ГАВЦГАЙЧ АВАРГЫН ЗАМ ӨЛЗИЙТЭЙ БАЙНА

Шинэвтэр «ЗИЛ—130» машиндаа цэвэрлэгээ хийж буй дунд зэргийн нуруутай дөч орчим насны эртэй баазын хашаанд уулзсан минь жолооч Цэрэндорж байв.

Цэрэндорж 1973 онд тээх ачааны төлөвлөгөөг 291 хувиар биелүүлэн, 296,6 мянган тонн километрийн ажил хийж аймгийн аварга тээвэрчин болжээ.

Ж.Цэрэндоржийн алтан шар зам одоогоос арваад жилийн тэртээ авто тээврийн 13 дугаар баазад ирж хуучинтар ЗИЛ—164 машин хүлээн авснаас эхэлжээ.

Чиргүүлтэй «ЗИЛ—130» машин алсын замд хурдлана. Ж.Цэрэндорж утгах замаа нүд салгалгүй ширтэн, жолоогоо чадамгай зална.

—Жолооч хүн замаа сайн мэдэх нь сурагч хүнд тооны хурд цээжлэхтэй адил. Маш нарийн тохируулгатай машин тун бага шатахуун зарцуулна гэж БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, жолооч

Пүрэвжав, Р. Ёндон, Л. Самбуу-Ёндон нарыг зөвлөлийг Цэрэндорж байнга санаж явдаг билээ.

Хориодхон мянган тонн километр дутчихлаа. Цэрэндорж өнөөдөр ирэх ёстой хүн яачих нь энэвэ?

Лав л 60 гаруй мянган тонн километрийн ажил хийсэн байгаа даа. Үүнийг оруулчихвал баазын маань уралдаанд авсан үүрэг давж биелэх ёстой гэж эдийн засагч бодол болон тээвэрчнээ хүлээн суухад Ж. Цэрэндорж саринхаа тооцооноос хожимдохгүйг хичээн яаравч цасан шуурга үл явуулна.

Гэсэн ч зүтгэсээр. Замд нь нэг машин суусан байлаа. Очвол жолооч нь даарахын туйлд хүрчээ.

Цэрэндорж, жолоочийг кабиндаа оруулан замын хүнснээсээ өгч дулаацуулаад машины нь цаснаас гаргах ажилд оров.

Цасанд хий эргүүлсээр бензинээ дууссан байлаа.

Өөрийнхөө аймаг орох хэмжээт бензинээсээ хийн өгч машины нь асаалган

гас жилийн бараа гүйлгээ, ном, нийтийн хоол, талх үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг 100,0—102,3 хувиар, ноос, хөөвөр, хялгасны жилийн төлөвлөгөөг 100,0—135,0 хувиар биелүүлэв.

Ц. БАДАРЧ

чирлээ. Өөрийн нь машин мөн л хий эргэлээ. Бүтэн өдөр шахам оролдож арайхийн гарган өгч цааш явах замыг нь сайтар заан явууллаа.

Шуурга ч намдсангүй. Өнөөдөр аймаг орох төлөвлөгөө нэг хоноогоор хойшиллоо. Жилийн 4 улирлыг аян замд өнгөрөөдөг тээвэрчин хүмүүст энэ мэт амь өрсөлдсөн олон бэрхшээл тохиолдог.

Хаалган дээрээ «Аймгийн 1973 оны ачаа тонн километрийн аварга, саят нь бригадын гишүүн Ж. Цэрэндорж» гэж бичээстэй ТӨ 09—41 номерын «ЗИЛ—130» машин чиргүүлээ чирэн аяны замдаа хөдөллөө.

Аварга тээвэрчин Ж. Цэрэндорж V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 7 сарын өмнө биелүүлчихээд дараах таван жилийн ажилдаа гарч байгаань энэ билээ.


Аваргын алтан шар зам нь өлзийтэй байг.

С. ОТГОН

ЗУРАГ ДЭЭР: Баянцогт сумын хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б. Ажиаа өөрийн шавь МХЗЭ-ийн илгээлтийн эзэн, тус сумын саальчин С. Бүдмаа, хоньчин Ц. Туваан, А. Одгэрээ нарт мал маллагааны талаар зөвлөгөө өгч байгаа нь.

Д. БАДАРЧ-ийн авсан

гэрэл зураг



Аймгийн ХАА-н нэгдлийн бригадуудыг 1974 оны 2 дугаар улирлын зарим ажлаар социалист уралдаанд цуваагаар байр эзлүүлсэн дүн

№	Сумдын нэр	Бригадын нэр	Эзлэх байр
1	Баян-өнжүүл	Бүрд	1
2	Баянцагаан	Гурван-түрүү	2
3	Алтанбулаг	Алтан-овоо	3
4	Эрдэнэсант	Баян-уул	4
5	Мөнгөнморьт	Уржил ферм	5
6	Эрдэнэсант	Сайхан	6
7	Баян-өнжүүл	Цээл	7
8	Заамар	Ухаа	8
9	Баян-өнжүүл	Бараат	9
10	Баянцагаан	Баян-айраг	10
11	Мөнгөнморьт	Байдал	11
12	Баянцагаан	Өлзийт	12
13	Баянзүрх	Тэрэлж	13
14	Алтанбулаг	Ферм	14
15	Мөнгөнморьт	Бүрх	15
16	Эрдэнэсант	Угалзат	16
17	Баянцагаан	Алтат	17
18	Алтанбулаг	Жаргалант	18
19	Бүрэн	Хайрхан	19
20	Алтанбулаг	Алтанбулаг	20
21	Мөнгөнморьт	Хэрлэн	21
22	Бүрэн	Булангаа	22
23	Дэлгэрхаан	Давст	23
24	Дэлгэрхаан	Тарган	24
25	Лүн	Энх	25
26	Баянжаргалан	Жаргалант	26
27	Баянзүрх	Туул	27
28	Заамар	Тосон	28
29	Баянжаргалан	Баян-эрхтий	29
30	Сэргэлэн	Хөшиг	30
31	Баянзүрх	Баян-бүрд	31
32	Өндөрширээт	Наранбилэг	32
33	Эрдэнэ	Хушинга	33
34	Заамар	Ундарган	34
35	Өндөрширээт	Баян-туул	35
36	Лүн	Цагаан-уул	36
37	Өндөрширээт	Баясах	37
38	Сэргэлэн	Авдар	38
39	Бүрэн	Баянцогт	39
40	Эрдэнэсант	Алтан-уул	40
41	Өндөрширээт	Уянга	41
42	Баян	Цант	42
43	Эрдэнэ	Эрдэнэ-уул	43
44	Лүн	Өгөөмөр	44
45	Баян	Баян	45
46	Баян	Цавчир	46
47	Эрдэнэ	Нарстай	47

Баяндэлгэр сумын «Хэрлэн-баян» нэгдэл бригадуудынхаа ажлын дүнг ирүүлэгүй учир уралдаанд байр эзлүүлсэнгүй.

Аймгийн ХААУ газар

ХАА-н Нэгдлийн зөвлөл

ӨВС ХАДЛАН

ӨН ТАРГА

ӨВСНИЙ АМТ ЧАНАРЫГ АЛДАХГҮЙН ТӨЛӨӨ

Өвс хадланг уураг витамин бусад шим тэжээлт бодисоор арвин үед нь бэлтгэхтэй холбогдуулж доорхи зүйлийг зөвлөө.

Витаминт өвс

Үүнийг бэлтгэхэд буурцагт, үет ургамал зонхилсон хур хагдгүй, нуга хээрийн өвс тохиромжтой.

Хур бороо элбэг байгаа энэ жилийн нөхцөлд витаминт өвс бэлтгэхэд онц анхаарах зүйл бол түргэн хугацаанд зөв хатаах явдал юм.

Хадсан өвсийг сүүдэр сараачинд хатаах эсхүү хадсаны дараа 2 цаг орчим эврээгээ тармаж мөрлөх хэрэгтэй. Ингэж мөрлөсөн өвсөө 25—30 хувь чийгтэй байхад нь бухалдан 2—3 хоноосны дараа нуруулах буюу үүнээс бага чийгтэй болгож хаман бооно. Витаминт өвсөөр нуруу хийж байгаа үедээ сайн нягтаргал гишгэж орой талыг майхан хэлбэртэй шовгордуу, сууриараа цомхон хийнэ.

Халгай

Халгайн найрлаганд А, В, С, К зэрэг олон төрлийн витамин, үл төдөөлөгдөх олон төрлийн хүчил, бас иод, кальц, фосфор ихтэй учир зөв бэлтгэж чадвал сайн чанарын витаминт тэжээл болдог.

Хадаж авсан халгайг нойтноор нь овоолж 2—3 цаг байлгахад халж витаминт чанараа алддаг.

Иймд мод, бэржээний зэрэг материалаар майхан хэлбэрийн нуруу бүхий сараач бэлтгэж түүндээ 2-3 давхар сараалжин тавиур тавьж халгайг 15-20 см зузаан үелүүлэн тавьж хатаана.

Халгайг гар, тракторын хадуураар хадаж болно.

Өвсний чанарг анхаарах нь Хадсан өвсийг борооны усанд норгох нь нэн хортой. Мөн хурц халуун нанд өвсний сөл шим задарч шимт чанар нь муудаж хатуу хэврэг болж хураах тээх үед хорогдол их гардаг.

Өвсөн мушгиа хийх нь чанар сайтай хадлан бэлтгэх сайн арга юм. Үүнийг хийхдээ нэг хүн хадсан өвсийг хэсэг хэсгээр дээр дээрээс нь цуваруулан тавьж дарж өгөхөд нөгөө хүн мушгиж хэц шон модон дээр тавьж хатаана. Бороо элбэгтэй үед доорхи хэдэн аргыг ашиглавал зүйтэй.

Үүнд: Хадсан өвсийг түргэн хатаахын тулд газар дээр нь эргүүлэн дахин мөрлөж мөрлөсөн өвсийг мөрт нь хөрвүүлэх аргыг хэрэглэх нь ашигтай.

Хэрэв өвс, бороонд норвол бороо арилж хадсан өвсний өнгөний ус эгшиж гүймэгц эргүүлэх хэрэгтэй. Бухал норвол заавал залгаж хатаана.

Бухал нурууг хэдийчинэ чигжүү нягт хийвэл гол руугаа норж халж гэмтэх нь бага. Өвсний халгалтыг түргэтгэхийн тулд хадсан өвсийг газар дээр нь нэг юмуу хоёрсоо илүүгүй эргүүлнэ.

Хээрийн бүст өвсийг хадсанаас хойш газар дээр нь 1—2 цаг задгай хатаагаад дараа нь жишүү тармуураар мөрлөж мөрдээр нь хагас өдөр хиртэй хатаагаад бухалдана.

Ингэж хатаасан өвсөө оройн чийг унахаас өмнө нуруулдвал ашигтай.

М. САМДАН

БАРИЛГАЧДЫН АМЖИЛТ

Аймгийн Барилга угсралтын контор Ардын хувьсгалын 53 жилийн ойг угтаж ард түмний социалист уралдааны жил 1974 оны эхний хагас жилийн барилга угсралтын төлөвлөгөөг 472,8 мянган төгрөгөөр буюу 24,3 хувиар давуулан биелүүлж, хөдөл-

мөрийн бүтээмжийг 35 хувиар, нэг ажилчны өдрийн хөдөлмөр-таваарын бүтээл 48,5 хувиар тус тус дээшлэв.

Эхний хагас жилд нийт бригадууд бүтээлийн нормоо 100,7—111,3 хувиар биелүүлсний дотор Намсрай, Бор даргатай бригад

7—11,3 хувиар төлөвлөгөөг давуулж уралдаанд хошуучилж явна.

Барилгачдын энэхүү амжилт нь үйлдвэрлэлийн явцыг түргэтгэхийн тулд бригадуудын хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулж социалист уралдааныг олон хэлбэрээр өрнүүлж ажилласны үр дүн юм.

Н. ДАГВА

МОНГОЛЫН АВТО ТЭЭВЭРЧДИЙН ӨДӨР

Манай орны тээвэрчид жил бүрийн 7 дугаар сарын 15-нд тээвэрчдийнхээ өдрийг баяртайгаар ёслол төмдөглөдөг билээ.

Үүнээс гадна 1975 оны 7 дугаар сарын 15-нд Авто тээврийн 50 жилийн ойг төмдөглөх тухай МА ХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоолыг хүлээж аваад улс төр, хөдөлмөрийн идэвхээ өрнүүлэн хөдөлмөрлөж байна. Их ой угтаж БНМА У-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөлөөс манай орны авто тээврийн нийт байгууллагын дунд зарласан социалист уралдаанд идэвхжсэн тус аймгийн тээвэрчид 1974 оны төлөвлөгөөт зорилтыг хугацаанаас нь өмнө биелүүлэх хөдөлгөөн өрнүүлэн амжилт олж байна. Социалист уралдааны дээд хэлбэр СХ-ийн болон саятны төлөө хөдөлгөөн өрнөж аймгийн нийт тээвэрчдийн 40 гаруй хувь нь СХ-ийн, авто баазын тээвэрчдийн 83 хувь нь саятны төлөө хөдөл-

гөөнд хамрагдаад байна.

Үүний үр дүнд манай тээвэрчид V жилийн төлөвлөгөөг биелүүлэх бүрэн боломж олж СХ-ийн Зам ашиглалтын анги 5 жилийн төлөвлөгөөг жил хагасын өмнө биелүүлж ачаа, хүн тээвэр хангамжийн 5 жилийн төлөвлөгөөг 68—89,1 хувиар биелүүлээд байна.

Замчин Содном, тээвэрчин Ө. Шагдар, Цэрэндорж, Бадамгарав, Намсрайжав, Сэмжаан, засварчин Бат-очир, диспетчер Ишдаш, Батсүх нарын зэрэг хүмүүс V таван жилийн төлөвлөгөөг биелүүлсэн сайхан амжилтаар бусдыгаа хошуучилж явна.

Тээвэрчдийн улс төр, мэргэжил боловсрол дээшилж аймгийн бүх тээвэрчдийн 62,2 хувь нь дундаас дээш боловсролтой, 18,6 хувь нь 1, 2 дугаар зэрэгтэй болж авто аваарын хэрэг өнгөрсөн оны хагас жилийнхээс 50 хувиар буурч тээврийн

хэрэгслийн ашиглалт сайжирч байна.

Нийтийн ашиглалтын авто паркийн ашиглалтыг 1970 оныхоос 5,7 гүйлт ашиглалт 7,4, даац ашиглалт 1, ачаа эргэлт 18,1 хувиар тус тус нэмэгджээ. 1974 оны социалист уралдаанд Тээврийг удирдах газрын хамт олон тээвэр, зам засвар хангамжийн програмт ажлыг 1,2—4 хувиар биелүүлэх үүрэг авч парк ашиглалтыг 0,60, даац ашиглалтыг 0,96—д тус тус хүрэгж машины бүтээлийг төлөвлөсөн хэмжээнээс 9-өөс доошгүй хувиар дээшлүүлэн тээврийн өөрийн өртгийг 0,3 хувиар хямдруулав.

Социалист уралдаанаар жигүүрлэсэн тус хамт олон эхний хагас жилийн ачаа эргэлтийг 9,1 хувь, хүн эргэлтийг 36,3 хувь, зам засварын төлөвлөгөөг 2 дахин, хангамжийн бараа эргэлтийг 22,8 хувиар тус тус давуулан биелүүлж хөдөлмөрийн бүтээмжийг 22,2 хувиар

дээшлүүлж, өөрийн өртгийг 7,5 хувиар хямдруулсан дүнгээр Зам ашиглалтын анги хагас жилд аймагт 1 дүгээр байрт, авто бааз 3 дугаар байранд орлоо.

Иймд олсон амжилтаа улам бататгаж Авто тээврийн 50 жилийн ойг угтаж юуны өмнө төлөвлөгөөт зорилтыг тоо чанарын бүх үзүүлэлтээр давуулан биелүүлэх, саятны болон социалист уралдаанд амжилтан, ажилдаас авсан үүргийн биелэлтэнд хяналт тавьж дүгнэх шалгаруулах ажлыг сайжруулж, үүргээ ширхэгчлэн биелүлдэг болгож заншуулах нь зүйтэй байна.

Тээвэр зохион байгуулалт, диспетчерийн удирдлага, зохицуулалтыг сайжруулан сул гүйлтийг эрс багасгаж, ашиглалтын саатлыг өнгөрсөн оныхоос 35-аас доошгүй хувиар багасган тээвэрчин нэг бүр дээр рейсийн карт хөтлөж байвал зохино.

Засвар үйлчилгээний ажлын чанарыг сайжруулж засварын байр га-

раашийг тохижуулан ачих, тээвэрлэх ажлыг механикжуулах арга хэмжээнүүд авахын дээр тээврийн хэрэгсэл бүрийг ашиглалтанд оруулж тариа хураалт, фондын тэжээл тээврийг нийт тээвэрчид заавал гүйцэтгэх зорилт тавигдаж байна.

Тээврийн байгууллагад бүртгэл тооцооны ажил, социалист өмчийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өр авлага барагдуулах төсөв зардлыг хамдруулах, нэмэгдэл, урмилгал бий болгох явдал чухал байна.

Тээвэрчдийн боловсрол мэдлэгийн байдалд судалгаа хийж энэ хичээлийн жилээс эхлэн төднийг ерөнхий боловсролын сургуульд суралцуулах, мөн мэргэжлийн зэргийг ахиулах ажлын хэмжээг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, хэв журам аюул ослын зөрчилгүй, соёл хамт олон байгууллага хэсэг бригад болох хөдөлгөөнийг улам эрчимтэй өрнүүлбэл зохино.

Аймгийн ТУГ-ын дарга
Т. СЭР-ОД

• ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛД ТЭРГҮҮН ТУРШЛАГА НЭВТРҮҮЛБЕ •

ДЕПУТАТ БАЙНГЫН КОМИСС, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тус аймагт аймгийн АДХ-ын 105, сум хот, хороодын АДХ-ын 764 бүгд, 869 депутат ажилладаг бөгөөд АДХ-ын дэргэд аймгийн 9, сум, хот, хороодын АДХ-ын 73 байнгын комисс, түүний идэвхтнээр 524 хүн ажиллаж байна.

Аймаг, сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас депутат байнгын комиссын ажилд туслахын тулд уулзалт тайланг зохион байгуулалттай тавиулах эдэв бэлтгэж өгөх, хяналт шалгалт явуулахад нь унаа хүн хүчээр хангах, аж ахуйн төлөвлөгөөт зорилтын тухай мэдээлэл өгөх, захидал илгээх, гарын авлага товхимол гаргах, депутатын өдөрлөг явуулж ажлыг нь дүгнэх зэргээр нилээд ажлыг зохиож байна.

Бүх сум депутатын танхим байгуулсны дотор Баянжаргалан, Баяндэлгэр, Баянцагаан, Баянзүрх, Баянцогт, Борнуур, Эрдэнэсант, Баянчандмань сум, хороодын АДХ-ын депутатын танхим байнгын ажиллагаатай болжээ. Мөн депутат байнгын комиссын ажлыг сарулирлаар дүгнэж депутатын манлайлыг хүснэгтээр судалж хангын самбарт хөтөлж «депутат» сонинг сар, улиралд гаргадаг болов. Чуулган бүрийд депутатын өдөрлөг явуулж депутат нар ажлын турш-

лагаа харилцан ярилцдаг ба депутат нарт цаг үеийн ажил байдлаар семинар өгдөг юм.

Тус аймгийн орон нутгийн АДХ-ын байнгын комиссууд 1973 онд чуулганд хавсралт илтгэл 60, тайлан 32-ыг тавьсны гадна гүйцэтгэх захиргаалад 36 асуудал боловсруулан оруулж, албан газар байгууллагад 126 зөвлөмжийг өгч 235 удаа үзлэг шалгалт явуулсан байна.

Аймаг сумын депутатууд улиралд сонгогчид тойгоо 1-ээс доошгүй удаа уулзалт хийж эрэлт хүсэлтийг нь сонсож байна. Депутат байнгын комиссын ажлын арга барил Борнуур, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан сумдад нилээд дээшилж ирэв.

Депутат байнгын комиссын өөрийн нь идэвхтэй санаачлага, гүйцэтгэх захиргааны тал бүрийн тусламжийн үр дүнд олон байнгын комисс төрийн захиргааны байгууллагын өргөн хүрээтэй үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Баянчандмань хорооны АДХ-ын Гомбосүрэн даргатай хууль ёс, нийгмийн хэв журам сахиулах АДХ-ын комисс, Борнуур сумын Ганхүү даргатай хууль ёс соёл гэгээрэл ЭХ байнгын комисс, Заамарын Чогдон даргатай худалдаа үйлчилгээний

байнгын комиссын ажил тогтмолжиж, ажлаа улирлаар төлөвлөж ажилладаг ба байнгын комиссын гишүүдэд тодорхой ажил хариуцуулж гүйцэтгүүлдэг, цаг үеийн зарим хочорч байгаа ажилд үзлэг шалгалт явуулж дутагдлыг засуулдаг болжээ.

Аймаг, сумын АДХ-ын депутад ажил үйлсээрээ ямагт тэргүүн өгнөөнд явж сонгогчдыгоо үйл ажиллагаа ахуйгаараа үлгэрлэн манлайлж байна.

Аймгийн үйлдвэрүүдэд ажиллаж байгаа бүх депутатуудын 98 хувь нь норм төлөвлөгөөгөө давуулан биелүүлж байна.

Үүний дотор БНМАУ-ын худалдааны гавъяат ажилтан Дашзэвэг, аймгийн 4 удаагийн аварга барилгачин Намсрай, Алтанбулаг сумын хоньчин Цэрэндорж, Батсүмбэр сумын жолооч Буриад, Баян сумын саальчин Цэсэм, Баянжаргалан сумын хоньчин Дамчаа, «Анхдугаар таван жил» сонин үйлдвэрийн үсэг өрөгч Дэмид нарыг нэрлэж болно. Депутат байнгын комиссын ажлын бүтээлч ажиллагааг дээшлүүлэх нь гүйцэтгэх захиргаа байнгын комисс депутатуудын хамтын чармайлт санаачилгаас илэрхэн шалтгаална.

Г. НЯМБУУ

СУМЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА БАЙНГЫН КОМИСС

Борнуур сумын Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг төрийн байгууллагаас удирдах арга барилыг боловсронгуй болгохын тулд АДХ-ын депутат байнгын комиссын ажлыг сайжруулах талаар сүүлийн жилүүдэд нилээд ажлуудыг санаачлан хийж байна. Байнгын комиссуудыг өвлийн болон төлийн бэлтгэл, бойжилт, тариа хураалтын ажилд идэвхтэй оруулцуулдаг болжээ.

Тухайлбал байнгын шалгалтыг дээрх ажлуудад тогтмол явуулж гарсан дутагдалд уг комиссоос зөвлөмж өгүүлж биелэлтийг шалгадаг юм.

Сумын гүйцэтгэх захиргаа байнгын комиссын ажлыг улирал бүр дүгнэж цуваа дүнг депутатын танхимд тавьж сурталчилдаг байна.

Дээрхи ажлыг зохиож ирсний дүнд байнгын комиссын ажил тогтмолжиж

байгаагийн дотор залуучууд хууль ёс, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах байнгын комисс (дарга нь Ганхүү) САА-н хүнсний ногооны талбайн тариалсан хэсгийг услахгүй хатаах, услах ажлыг удаашруулах зэрэг дутагдалд шалгалт хийж зохих арга хэмжээ авсны гадна сумын төв зарим бригаддад иргэний үүргийн биелэлтийг шалгаж дүнг ээлжит чуулганд оруулж хэлэлцүүлсний дээр сумын ХЗЭ-ийн байгууллагатай хамтран хууль зүйн сэдэвт лекц яриа гэгээрлийн хурал хийжээ.

Мөн байнгын комиссын гишүүн Хүрэл, Цэнд, Чимгээ, Гомбосүрэн, Дашням нарыг өгөгдсөн ажлыг тухай бүр гүйцэтгээд ажлынхаа үр дүнг байнгын комисст сар, улирал бүр тогтмол мэдээлж дараагийн хийх ажлаа авч ажилладаг байна.

Г. БАТХҮҮ

ТОВЧХОН

Баянжаргалан сумын АДХ-ын депутатууд өөрийн тойрогтоо иргэний үүргийн биелэлтээр социалист уралдаан өрнүүлж түүнийг 10 хоног тутам шалган дүгнэж иргэний үүргийн биелэлтээр хэсэг дотор нь байр эзлүүлж дүгнэдэг юм.

Депутатуудад сумын төвийн албан газар айл өрхийг хуваарилж тэдгээрийн ариун цэвэр иргэний үүргийн биелэлт социалист өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг шалгуулдаг болсноор Баянжаргалан суманд иргэний үүргийн биелэлт цаг хугацаандаа бүрэн биелэгддэг болов.

НЭГЭН БАЙНГЫН КОМИСС

Баянчандмань хорооны АДХ-ын дэргэдэх социалист хууль ёс, нийгмийн хэв журам сахиулах, залуучуудын асуудал эрхэлсэн байнгын комисс ажлаа жил улирлаар төлөвлөн ажиллаж түүний гүйцэтгэлийг удирал тутам гарган дүгнэж зохиосон ажлын талаар хорооны нийт хөдөлмөрчдөд тайлагнадаг байна.

Мөн комиссын идэвхтнээр 10 хүн бүртгэн авч ажил хуваарилан ажиллуулсний зэрэгцээ хорооны нийт ажилчид хөдөлмөрчид мэргэжилтнээр хэтнүүдийг түшиглэж олон нийтийн байгууллагатай хамтарч ажлаа явуулдаг нь үр дүнгээ өгч байна. Хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаатай хамтран ажилчин албан хаагчид хөдөлмөрчдөд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигууд газар эдэлбэр, ус ашиглалт ой, ан, гэр бүл, хөдөлмөрийн хуулиудыг тусгай программаар зааж шалгалт авах, аймгийн хэсгийн прокурорыг урьж зөвлөлтөө өгүүлэх хууль сурталчлах 7 хоногийн сэдэвт ажлуудыг үе үе зохиож БНМАУ-ын баа-

тар Хаянхярваа, ардын гэгээрлийн тэргүүний ажилтан Балжинням нартай залуучуудыг уулзуулж үндэслэг уулзалт зохиох, хуулийн сэдэвт лекц унших зэрэг ажлыг зохиож байна. Бүх байгууллага тасаг, бригад, фермийг хуулийн булантай болгож түүнийг судлуулах, эд хариуцагч манаач нараас ажил төрлийн холбогдолтой хуулиудаар шалгалт авав.

Байнгын комиссын гишүүд зарим мэргэжилтний оролцуулан мал аж ахуйн туршлага ферм, нийтийн аж ахуйн ба худалдаа бэлтгэлийн анги зэрэг газарт төлөвлөгөөт ажлыг шалгаж төлөвлөгөө, биелүүлэхийн учир холбогдлыг бүх ажилчдад яриа хийж зөвлөгөө өгдөг юм.

Үүний үр дүнд Баянчандмань хэмжээгээр эд хариуцагчийн хариуцлага дээшилж скалад бараа материалын эмх цэгц сайжирч, социалист өмч хөрөнгийг идэж ашиглах, нийгмийн хэв журам зөрчих явдал сүүлийн 2 жил гараагүй байна.

Л. ДАШЦЭРЭН

ЗАХИАА ДААЛГАВРЫН ХАРИУД

АДХ-ыг сонгох сонгуулийн аль нэг тойргийн сонгогчдоос гаргасан улс ардын аж ахуйн төлөвлөгөөт даалгаврыг биелүүлэх, төрийн аппаратын үйл ажиллагааг сайжруулах хүн амын хамгийн шаардлагатай эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн улс орон нутгийн чанартай аливаа асуудал сонгогчийн захиа даалгаврын үндэс болдог.

АДХ-ыг сонгох сонгуулийн тойргийн сонгогчид депутатад нэр дэвшигчид тэй уулзах сонгуулийн өмнөх уулзалт болон депутатын тайлан сонсох хурлаас уул тойрогт сонгогдсон депутатад захиа даалгавар өгдөг.

Орон нутгийн АДХ-ыг сонгох 10 дахь удаагийн сонгуулийн депутатад өгсөн захиа даалгаварт үйлдвэр, ХАА, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах, хөдөлмөрчдийн ахуй үйлчилгээг сайжруулахтай холбогдсон олон арван санал, эрэлт хүсэлт илэрхийлэгдсэн байна.

Үүний дагуу аймаг сум, хот, хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргаад сон-

гогчдын захиа даалгаврыг биелүүлэх төлөвлөгөө боловсруулан анхдугаар чуулганаар хэлэлцүүлж түүнээ мөрдөн ажиллаж байна.

Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, АДХ-ын депутат байнгын комиссууд сонгогчдын захиа даалгавар биелүүлэх талаар зохион байгуулалт хяналт шалгалтын ажлаа чиглүүлэн орон нутгийн нөөц бололцоог ашиглах замаар нийт хөдөлмөрчдийн идэвх хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллаж байна.

Арав дахь удаагийн сонгуулийн хугацаанд аймгийн АДХ-ын депутатад өгсөн бүх захиа даалгаврын 65 хувь, сум, хот, хороодын АДХ-ын депутатад өгсөн захиа даалгаврын 75 хувь нь биелэгдээд байна. Нам засгаас авч байгаа арга хэмжээний үр дүнд улс ардын аж ахуйн төлөвлөгөөгөөр зохицуулагдаж ардын боловсрол эрүүлийг хамгаалах талаар сургууль хүн эмнэлгийн байр барих дотоод төхөөрөмжөөр хангах, түргэн тусламжийн машин олгох, нэг-

дэл САА-н тасаг бригаддад бага эмчийн салбар, цэцэрлэг, сургууль байгуулах, хөдөлмөрчдийн ахуй үйлчилгээг сайжруулах зорилгоор худалдаа нийтийн хоолны цэг салбар байгуулах өргөн хэрэгцээний бараа хүнсний бүтээгдэхүүнээр хангах зэрэг захиа даалгавар биелэгдэж байна.

Гэвч сонгогчдын захиа даалгавар тэр бүр биелэгдэхгүй хугацаа алдагдах явдал байсаар байна.

Иймд АДХ-ын депутатууд сонгогчдын захиа даалгаврыг хүлээж аваад аймаг, сум, хороодын гүйцэтгэх захиргаалад дамжуулах төдий биш сонгуулийн бүрэн эрхийн хугацааны турш сонгогчдын захиа даалгаврыг нэр төртэй биелүүлэхийн төлөө хамаг анхаарал хүчээ дайчлан ажиллах нь чухал.

Сонгогчдын захиа даалгавар нь ард түмний зориг хүсэлт тэдний зайлшгүй чухал хэрэгцээг илэрхийлсэн байдаг учраас тэр нь ажил хэрэг болж байх ёстой.

Н. ОЮУНДАЙ

АРИУН ЦЭВРИЙН САРЫН АЖИЛ ЭХЭЛЛЭЭ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 231 дүгээр тогтоолын дагуу энэ оны 7 дугаар сарын 15-наас ариун цэврийн сарын ажил эхэллээ.

Ариун цэврийн сарын ажлын гол зорилт нь ахуйд соёл нэвтрүүлэх, хот суурин газар хүн ам, айл өрхийн ариун цэврийн байдлыг сайжруулах явдал мөн. Үүний тулд төв суурин, албан үйлдвэр үйлчилгээ, айл өрхийн бие засах газар, бохир усны цооногийг шаардлагын дагуу засч тохижуулах, шинээр барих, хог хаягдлыг цэвэрлэх, түүнийг цуглуулах тээвэрлэх асуудлыг боловсронгуй болгох, усны эх бүлгийг бохирдлоос хамгаалах ар-

га хэмжээ авах, хүмүүсийн хувийн болон айл өрхийн ариун цэврийг сайжруулах, ахуйд соёлыг нэвтрүүлэх ажил хийгдэнэ.

Ариун цэврийн сарын ажлыг сум, хот, хороо-дын АДХ-ын гүйцэтгэх захиргаагаас зохион байгуулж, энэ ажилд улс, олон нийт, албан үйлдвэр, үйлчилгээний байгууллага, олон нийтийн ариун цэврийн байцаагчдыг өргөнөөр оролцуулан ард иргэдийг хамруулсан бүх нийтийн ажил болгон явуулах учир сарын ажлын зорилт ач холбогдлыг хөдөлмөрдөд өргөн сурталчилж уг ажлыг дайц үр дүнтэй зохиох явдал чухал байна.

Л. ЖАНЧИВ

Сонинд ирсэн захидал

НОМЫН САНГААР

САЙН ҮЙЛЧЛЭЭСЭЙ

Сэргэлэн сум-нэгдлийн дэргэдэх номын сангийн ажиллагаа тун хангалтгүй байна. Сум-нэгдлийн захиргаа муу анхаарч байгаагаас сумын номын сангийн номын фонд нэмэгдээгүй, хуучин хэдхэн төрлийн номтой, шинээр ном авахад нэгдлийн зөвлөлөөс мөнгийг нь шилжүүлж өгдөггүй ажээ.

Номын сангийн өрөө байр нь тохижилтоор муу, уншлагын тасалгаа байхгүй учраас байгуулагдсан цагаас хойш номын санд ном уншсан хүн ховор

байна. Цаг үеийн ээлжит ажлын үеэр номын сангийг ажиллуулахгүй, аар саар ажилд явуулж байжээ.

Иймд номын санг уншигчдын хэрэгцээт ном хэвлэлээр зохих цагт нь хангах, тогтмол үйлчилгээтэй болгож номын сангийг үр бүтээлтэй ажиллуулах нөхцөл бололцооны талаар газар дээр нь шалган үзэж тодорхой арга хэмжээ авч өгөхийг соёлын хэлтсийн даргын сонорт аймгийн сониндоо дамжуулан хүргэе.

Д. САНЖААЖАМЦ



Зуунмод хотын 2 дугаар цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Х. Мянганбаяр хүүхдүүдэд дуу хөгжмийн чээлийг чанартай сайн заадаг юм.

Ахмад малчдын залуу халаа

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭД

Д.Сүхбаатар Улаанбаатар хотын 13 дугаар сургуулийн 7 дугаар ангийг төгсөхдөө хөдөө нутагт очиж хоньчин болохоор МХЗЭ-ийн илгээлт өвөрлөн Эрдэнэсант суманд очсноос хойш 3 жил болжээ. Ахмадуудынхаа залуу халаа болохоор Дондогийн хүү Сүхбаатарыг ирэхэд нь уугуул нутгийн малчин олон халуун талархалтай хүлээн авч, хашир малчин Галданжамцын туслах хоньчноор ажиллуулжээ.

Д. Сүхбаатар хоньчин болох хүслээ биелүүлэхээр нэгэн бүлийн ах дүү-

сэг хамт олныхоо хайр ивээлд бүүвэйлэгдэн бүтээлч хөдөлмөрийн үр шимийг хүртэж хөдөлмөрсөний үрээр 1973 онд 368 хони ноос 368 хурга бойжуулан хонь нэгбүрээ 68 кг жинд хүргэн таргалуулж 1974 оны хавар 259 хонь, ямаа төл үлүүлж 261 хурга бойжуулан 134 ямаа нэгбүрээс 260 грамм ноолуур авахаас 337 грамм авч ажлын амжилт арвинтай аймгийнхаа илгээлтийн эздийн анхдугаар чуулганд оролцлоо. Илгээлтийн эзний аялж зорьсон ажил үйлс нь өөдрөг бүтэмжтэй байснаас 1972 онд

«Тэргүүний малчин залуу» алтан медалиар шагнагдаж, 1973 онд зохиолч Зандраабайдын «Өглөөний наран айсуу» туужийн гол баатар болон бичигдэж алдар нэрээ дуурсган улам шинэ амжилт өөд урам зоригтой замнаж явна.

Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдлийн хоньчин илгээлтийн эзэн Г. Лхамсүрэн 1973 онд 358 эм хонь, 141 эм ямаа төлүүлж 100 эхээс 99 төл бойжуулж үйлдвэрлэлийн даалгаврыг 100-108 хувиар, нэгдлийн үйлдвэрлэлийн даалгавраа 100-103 хувиар биелүүлж ямаа нэгбүрээсээ 292 грамм ноолуур авахаас 330 грамм ноолуур авсан байна.

Д. БАДАРЧ

Зөвлөлгөө

Тамхины хор

Тамхи нь хүний бие махбодид хор нөлөө үзүүлж эрүүл бие, саруул ухааныг эрэмдэг болгодог гэхэд эргэлзэх хүн үгүй болжээ. Тамхины утаанд 30 гаруй төрлийн хортой бодис байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн их хортой нь никотин юм.

Никотин нь тамхичин хүний биеийг гэнэт шууд хордуулахгүй харин бие махбодид аажим дасах замаар далдуур хордуулдаг. Тамхинд никотиноос гадна нүүрс хүчлийн хий (угаарын хий) нүүрсний болон хөхөмдөг хүчил, хүхэрт ус төрөгч, шүвтэр эфирийн тос зэрэг хортой бодисын зэрэгцээгээр радио идэвхт элемент (полон) цацраг идэвхт бодисууд тодорхой хэмжээгээр байдаг нь судалгаагаар нотлогджээ.

Тамхины 25 хувь нь шатаж алга болно. 50 хувь нь орчины агаарт тархаж, 20 хувь нь хүний биед нэвтэрч 5 хувь нь тамхины ишинд үлддэг гэсэн судалгаа байна. Тамхины утаа нь хүний бүхий л бие махбодыг хордуулдгаас эвчлэх хүний зүрхэнд үзүүлэх хор хөнөөлийн тухай дурьдая. Тамхи татсаны дараах 21-23 секундэд никотин нь шингэж цусаар дамжин тархаж цус-

ны эргэлтийн эрхтэн зүрх судсыг хордуулдаг.

Тамхи татдаг хүний зүрхний булчин өөхөлж зүрхний ажиллах чадвар нь суларна. Тамхи татдаггүй эрүүл хүний зүрх хоногт 100000 удаа агшдаг байхад тамхичин хүний зүрх 20000-25000 удаа агшдаг. Тамхичин хүний цусны судас нарийссанаас судсаар явж эд эрхтэнг тэжээдэг цусны урсгал удааширч бие махбодид тэжээл дутагдахад хүрнэ. Олон жилийн судалгааны үр дүнд зүрх судасны өвчнөөр өвчлөгсдийн ихэнх хувийг тамхи татдаг хүмүүс эзэлдэг нь тодорхойлогдлоо.

Тамхи татсаны улмаас цусны даралт ихдэх, судас хатуурах зүрхний булчингийн шигдэн зүрхний булчингийн үрэвсэл буй болох зэрэг амь насанд аюултай зүрх судасны хүнд өвчнийг үүсгэх нөхцөлийг бүрэлдүүлдэг.

Эдгээр өвчнөөр өвчлөхгүй байх буюу өвчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд тамхийг татахгүй байх буюу тамхи-наас гарах явдал чухал.

Энэ нь гагцхүү хүний санаа зориг тэсвэр хатуужлаас л шалтгаална. Ингэхлээр зүрх судас бие махбодыг хордуулагч тамхинаас гарцаагай.

АУДС-ийн оюутан
С. ДЭМБЭРЭЛСҮРЭН
С. ПҮРЭВСҮРЭН

СЕЛАХ БУТБАЙН 117 ДАХЬ ХАВАР

Абхазын уулан дахь Очамчирскийн районы Атаратосгонд 117 настай хамтралчин Селах Шабо-вич гуай 90 настай байхдаа ч уулынхаа бэлчээрт хонин сүргээ хариулсаар л байлаа.

Түүний эцэг Шааб 122 насандаа бие барж, ах Едга нь 100 насалжээ.

Селах Бутбайг 70 настай нь түүний долоо дахь хүүхдүүд нь хоёр ихэр Селах Костя, Селах Валика нар нь төржээ.

Одоо эднийхэн гэр бүлээрээ 70 гаруй хүн байгаа юм. Гэргий Селах Маруша нь эдүгээ 89 настай. Өндөр настнууд маань өнөөдөр ч гэсэн хамтралчинхаа тамхи, эрдэнэшиш ургуулах ажилд туслахаар л байна.

Харин Селах Бутбайтай хамтралын ногооны талбайд эсвэл зөгийг тэжээх газар юмуу усан үзмийн ороонгонд очиж уулзаж болно.

Тэрээр цэцэрлэгч төдийгүй сайн анчин хүн юм. Би нэгэн удаа тэд-

нийд зочлон очсон юм.

Бутбай гуайг гэртээ байсангүй. Анхдугаар байлаа. Тэр бүр орой болсон хойно хоёр үнэгний арьс барьсаар орж ирээд наадтай мэнд мэдэлцсэний дараа үнэгнийхээ арьсыг хаха руугаа шидчихээд: «Өнөөдөр бол миний амьдралд хэзээч мартагдашгүй өдөр боллоо.

Цагаан хэрээ үздэг юм байна. Бүр цав цагаан шүүг 100 наслахад амьдралд ганц удаа л тохиолддог юм байна гээд өөр бас нэг тохиолдлоо дурсан ярьсан нь: Янгир хамгийн өндөрт хярладаг, зуны дунд сарын тийм нэгэн өдөр юмсан. Тэгэхэд би 30 настай залуу эр, гэрлээгүй явсан юм.

Би эгц ханан хясаа өөд мансаар мөсөн голд хүрээд сууж байлаа.

Асганы нуранги чулуу шижигнэн урсах чимээ гарлаа.

Ойролцоо янгир явна даа гэж бодоод анирч чимээ өгөлгүй чагнаад л

байлаа. Удлаа! Хавь ойрынхоо бүртнийх сэртнийх бүхнийг ажиглаад сууж байтал гэнэтхэн нүдний үзүүрт нэг цагаан юм харгад шиг болов.

Тэгтэл маш том эвэртэй цагаан амьтан мөсөн гол руу хүрээд ирлээ. Мундаг том ямаа юмуудаа гэж гайхаад ширтээ байлаа. Бас ямаанд чинь юуны нь тийм том эвэр байх билээ дээ.

Янгир юмаал Цав цагаан янгир миний эгц урьдаас хараад зогсож байлаа. За хүү минь би ингэж л цагаан янгир байдгийг нүдээрээ харсан юм. Цав цагаан янгир байдгийг хэн хэзээч урьд өмнө үзээгүй юм.

Чи ч гэсэн илгээгүй. Абхазыхан шиг өндөр настай ард түмний хэн нь ч гэсэн тийм сойни амьтантай тааралдах л биздээ гэж Селах Бутбай гуай ярьсан юм.

Огонёк сэтгүүлийн энэ оны 14 дүгээрээ С. Санзий-жамц орчуулав.

ТОВЧХОН

1971 онд ЗХУ-ын тусламжтайгаар Угтаал, Жаргалантын САА-д үр хадгалах механикжсан агуулах 2-ыг барьж өгсөнөөр жил бүр намрын тариалалтаас шилмэл сортын мөн гадаадаас ирж байгаа үрийг агротехникийн хэвийн ажиллагааг нь алдагдуулахгүй хадгалж

байна. Жаргалантын САА дахь үр тарианы улсын нөөцийн агуулах нь 1974 оны хаврын тариалалтаар Сэлэнгэ аймгийн Орхон-туулын САА-д 1800 тонн үр, Угтаалын САА дахь үрийн нөөцийн салбараас Булган, Завхан, Баянхонгор аймгийн нэгдлүүдэд 1000-аад тонн үр тус тус борлуулав.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

АРИУН ЦЭВРИЙН САРЫН АЖИЛ ЭХЭЛЛЭЭ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 231 дүгээр тогтоолын дагуу энэ оны 7 дугаар сарын 15-наас ариун цэврийн сарын ажил эхэллээ.

Ариун цэврийн сарын ажлын гол зорилт нь ахуйд соёл нэвтрүүлэх, хот суурин газар хүн ам, айл өрхийн ариун цэврийн байдлыг сайжруулах явдал мөн. Үүний тулд төв суурин, албан үйлдвэр үйлчилгээ, айл өрхийн бие засах газар, бохир усны цооногийг шаардлагын дагуу засч тохижуулах, шинээр барих, хог хаягдлыг цэвэрлэх, түүнийг цуглуулах тээвэрлэх асуудлыг боловсронгуй болгох, усны эх булгирт бохирдлоос хамгаалах ар-

га хэмжээ авах, хүмүүсийн хувийн болон айл өрхийн ариун цэврийг сайжруулах, ахуйд соёлыг нэвтрүүлэх ажил хийгдэнэ.

Ариун цэврийн сарын ажлыг сум, хот, хороо-дын АДХ-ын гүйцэтгэх захиргаадаас зохион байгуулж, энэ ажилд улс, олон нийт, албан үйлдвэр, үйлчилгээний байгууллага, олон нийтийн ариун цэврийн байцаагчдыг өргөнөөр оролцуулан ард иргэдийг хамруулсан бүх нийтийн ажил болгон явуулах учир сарын ажлын зорилт ач холбогдлыг хөдөлмөрчлөд өргөн сурталчилж уг ажлыг далайц үр дүнтэй зохиох явдал чухал байна.

Л. ЖАНЧИВ

Сонинд ирсэн захидал

НОМЫН САНГААР

САЙН ҮЙЛЧЛЭЭСЭЙ

Сэргэлэн сум-нэгдлийн дэргэдэх номын сангийн ажиглагаа тун хангалтгүй байна. Сум-нэгдлийн захиргаа муу анхаарч байгаагаас сумын номын сангийн номын фонд нэмэгдээгүй, хуучин хэдхэн төрлийн номтой, шинээр ном авахад нэгдлийн зөвлөлөөс мөнгийг нь шилжүүлж өгдөггүй ажээ.

Номын сангийн өрөө байр нь тохижилтоор муу, уншлагын тасалгаа байхгүй учраас байгуулагдсан цагаас хойш номын санд ном уншсан хүн ховор

байна. Цаг үеийн ээлжит ажлын үеэр номын сангийг ажиллуулахгүй, аар саар ажилд явуулж байжээ.

Иймд номын санг уншигчдын хэрэгцээт ном хэвлэлээр зохих цагт нь хангах, тогтмол үйлчилгээтэй болгож номын сангийг үр бүтээлтэй ажиллуулах нөхцөл бололцооны талаар газар дээр нь шалган үзэж тодорхой арга хэмжээ авч өгөхийг соёлын хэлтсийн даргын сонорт аймгийн сониноор дамжуулан хүргэе.

Д. САНЖААЖАМЦ



Зуунмод хотын 2 дугаар цэвэрлэлийн хүмүүжүүлэгч Х. Мянганбаяр хүүсдүүдэд дуу хөгжмийн чээлийг чамартай сайн заадаг юм.

Ахмад малчдын залуу халаа

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭД

■ Д. Сүхбаатар Улаанбаатар хотын 13 дугаар сургуулийн 7 дугаар ангийг төгсөхдөө хөдөө нутагт очиж хоньчин болохоор МХЗЭ-ийн илгээлт өөрчлөн Эрдэнэсант суманд очсноос хойш 3 жил болжээ. Ахмадуудынхаа залуу халаа болохоор Дондогийн хүү Сүхбаатарыг ирэхэд нь уугуул нутгийн малчин олон халуун талархалтай хүлээн авч, хашир малчин Галданжамцын туслах хоньчноор ажилдуулжээ.

Д. Сүхбаатар хоньчин болох хүслээ биелүүлэхээр нэгэн бүлийн ах дүү-

сэг хамт олныхоо хайр нивээлд бүүвэйлэгдэн бүтээлч хөдөлмөрийн үр шимийг хүртэж хөдөлмөрлөсний үрээр 1973 онд 368 хони ноос 368 хурга бойжуулан хонь нэгбүрээ 68 кг жинд хүргэн таргалуулж 1974 оны хавар 259 хонь, ямаа төлүүлж 261 хурга бойжуулан 134 ямаа нэгбүрээс 260 грамм ноолуур авахаас 337 грамм авч ажлын амжилт арвинтай аймгийнхаа илгээлтийн эздийн анхдугаар чуулганд оролцлоо. Илгээлтийн эзний аялж зорьсон ажил үйлс нь өөдрөг бүтэмжтэй байснаас 1972 онд

«Тэргүүний малчин залуу» алтан медалиар шагнагдаж, 1973 онд зохиолч Зандраабайдийн «Өглөөний наран айсуу» туужийн гол баатар болон бичигдэж алдар нэрээ дуурсган улам шинэ амжилт өөд урам зоригтой замнаж явна.

■ Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдлийн хоньчин илгээлтийн эзэн Г. Лхамсүрэн 1973 онд 358 эм хонь, 141 эм ямаа төллүүлж 100 эхээс 99 төл бойжуулж үйлдвэрлэлийн даалгаврыг 100—103 хувиар биелүүлж ямаа нэгбүрээсээ 292 грамм ноолуур авахаас 330 грамм ноолуур авсан байна.

Д. БАДАРЧ

Зөвлөлгөө

Тамхины хор

Тамхи нь хүний бие махбодид хор нөлөө үзүүлж эрүүл бие, саруул ухааныг эрэмдэг болгодог гэхэд эргэлзэх хүн үгүй болжээ. Тамхины утаанд 30 гаруй төрлийн хортой бодис байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн их хортой нь никотин юм.

Никотин нь тамхичин хүний биеийг гэнэт шууд хордуулахгүй харин бие махбодид аажим дасах замаар далдуур хордуулдаг. Тамхинд никотиноос гадна нүүрс хүчлийн хий (угаарын хий) нүүрсний болон хөхөмдөг хүчил, хүхэрт ус төрөгч, шүвтэр эфирийн тос зэрэг хортой бодисын зэрэгцээгээр радио идэвхт элемент(полон) цацраг идэвхт бодисууд тодорхой хэмжээгээр байдаг нь судалгаагаар нотлогджээ. Тамхины 25 хувь нь шатаж алга болно. 50 хувь нь орчины агаарт тархаж, 20 хувь нь хүний биед нэвтэрч 5 хувь нь тамхины ишинд үлддэг гэсэн судалгаа байна. Тамхины утаа нь хүний бүхий л бие махбодыг хордуулдагас эвчнөн хүний зүрхэнд үзүүлэх хор хөнөөлийн тухай дурьддаг. Тамхи татсаны дараах 21—23 секундэд никотин нь шингэж цусаар дамжин тархаж цус-

ны эргэлтийн эрхтэн зүрх судсыг хордуулдаг.

Тамхи татдаг хүний зүрхний булчин өөхөлж зүрхний ажиллах чадвар нь суларна. Тамхи татдаггүй эрүүл хүний зүрх хоногт 100000 удаа агшдаг байхад тамхичин хүний зүрх 20000—25000 удаа агшдаг. Тамхичин хүний цусны судас нарийссанаас судсаар явж эд эрхтэнг тэжээдэг цусны урсгал удааширч бие махбодид тэжээл дутагдахад хүрнэ. Олон жилийн судалгааны үр дүнд зүрх судасны өвчнөөр өвчлөгсдийн ихэнх хувийг тамхи татдаг хүмүүс эзэлдэг нь тодорхойлогджээ.

Тамхи татсаны улмаас цусны даралт ихдэх, судас хатуурах зүрхний булчингийн шигдэн зүрхний булчингийн үрэвсэл буй болох зэрэг амь насанд аюултай зүрх судасны хүнд өвчнийг үүсгэх нөхцөлийг бүрэлдүүлдэг.

Эдгээр өвчнөөр өвчлөхгүй байх буюу өвчлөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд тамхийг татахгүй байх буюу тамхинаас гарах явдал чухал.

Энэ нь гагцхүү хүний санаа зориг төсвэр хатуужлаас л шалтгаална. Ингэхлээр зүрх судас бие махбодыг хордуулагч тамхинаас гардагаар.

АУДС-ийн оюутан

С. ДЭМБЭРЭЛСҮРЭН

Э. ПҮРЭВСҮРЭН

ТОВЧХОН

1971 онд ЗХУ-ын тусламжтайгаар Угтаал, Жаргалантын САА-д үр хадгалах механикжсан агуулах 2-ыг барьж өгсөнөөр жил бүр намрын тариалтаас шилмэл сортын мөн гадаадаас ирж байгаа үрийг агротехникийн хэвийн ажиллагааг нь алдагдуулахгүй хадгалж

байна. Жаргалантын САА дахь үр тарианы улсын нөөцийн агуулах нь 1974 оны хаврын тариалалтаар

Сэлэнгэ аймгийн Орхон-туулын САА-д 1800 тонн үр, Угтаалын САА дахь үрийн нөөцийн салбараас Булган, Завхан, Баянхонгор аймгийн нэгдлүүдэд 1000-аад тонн үр тус тус борлуулав.

СЕЛАХ БУТБАЙН 117 ДАХЬ ХАВАР

Абахазын уулан дахь Очамчирскийн районь Атаратосгонд 117 настай хамтралчин Селах Шаабович гуай 90 настай байхдаа ч уулынхаа бэлчээрт хонин сүргээ хариуцаар л байлаа.

Түүний эцэг Шааб 122 насандаа бие барж, ах Едга нь 100 насалжээ.

Селах Бутбайг 70 настайд нь түүний долоо дахь хүүхдүүд нь хоёр ихэр Селах Костя, Селах Валика нар нь төржээ.

Одоо эднийхэн гэр бүлээрээ 70 гаруй хүн байгаа юм. Гэргий Селах Маруша нь эдүгээ 89 настай. Өндөр настнууд маань өнөөдөр ч гэсэн хамтралынхаа тамхи, эрдэнэшиш ургуулах ажилд туслахаар л байна.

Харин Селах Бутбайтай хамтралын ногооны талбайд эсвэл зөгийг тэжээх газар юмуу усан үзэмийн ороонгонд л очиж уулзаж болно.

Тэрээр цэцэрлэгч төдийгүй сайн анчин хүн юм. Би нэгэн удаа тэд-

нийд зочлон очсон юм.

Бутбай гуайг гэртээ байсангүй. Андвичихсан байлаа. Тэр бүр орой болсон хойно хоёр үнэгний арьс барьсаар орж ирээд наадтай мэнд мэдэлцсэний дараа үнэгнийхээ арьсыг хана руугаа шидчихээд: «Өнөөдөр бол миний амьдралд хэзээч мартагдашгүй өдөр боллоо.

Цагаан хэрээ үздэг юм байна. Бүр цав цагаан шүүл 100 наслахад амьдралд ганц удаа л тохиолддог юм байна гээд өөр бас нэг тохиолдлоо дурсан ярьсан нь: Янгир хамгийн өндөрт хярладаг, зуны дунд сарын тийм нэгэн өдөр юмсан. Тэгэхэд би 30 настай залуу эр, гэрлээчгүй явсан юм.

Би эгц ханан хясаа өөд малцаар мөсөн голд хүрээд сууж байлаа.

Асганы нуранги чулуу шижигнэн урсах чимээ гарлаа.

Ойролцоо янгир явна даа гэж бодоод анирч чимээ өгөлгүй чагнаад л

байлаа. Удлаа! Хавь ойрынхоо бүртгийх сэртийх бүхнийг ажиглаад сууж байтал гэнэтхэн нүдийн үзүүрт нэг цагаан юм харгалдах шиг болов.

Тэгтэл маш том эвэртэй цагаан амьтан мөсөн гол руу хүрээд ирлээ.

Мундаг том ямаа юмууда гэж гайхаад ширтэж байлаа. Бас ямаанд чинь юуны нь тийм том эвэр байх билээ дээ.

Янгир юмаа! Цав цагаан янгир миний эгц урьдаас хараад зогсож байлаа. За хүү минь би ингэж л цагаан янгир байдгийг нүдээрээ харсан юм. Цав цагаан янгир байдгийг хэн хэзээч урьд өмнө үзээгүй юм.

Чи ч гэсэн ялгаагүй, Абахазынхан шиг өндөр настай ард түмний хэн нь ч гэсэн тийм сойнон амьтантай тааралдах л биздээ гэж Селах Бутбай гуай ярьсан юм.

Огөнбэ сэтгүүлийн энэ оны 14 дүгээрээс О. Санжай-жамц орчуулав.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОНУУ